

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН БАЙЦААГЧ,
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН АЛТАНГЭРЭЛИЙН МӨНХЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ
ЭЦСИЙН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
1.1 НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:							
1.1.1 Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл зөв амьдралын дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.							
1.1.1.1	Арга хэмжээ: Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан хөтөлбөрт албан хаагчдыг хамруулах	-	Хамрагдсан албан хаагчдын тоо	-	3	Тухайн үйл ажиллагааг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.	-
1.1.2 Нийслэл, дүүргийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийг засаг, нийгмийн хөгжилд чиглүүлэн, үр ашигтай төлөвлөж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлнэ.							
1.1.2.1	Арга хэмжээ: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, сан, санхүү, хүний нөөцийн ил тод байдлыг олон нийтэд мэдээлж ажиллах	-	Мэдээллийг мэдээллэсэн тоо	12	6	Шилэн дансанд байршуулах хүний нөөцтэй холбоотой бүтэц орон тооны, тушаал шийдвэр, нийтийн албаны тухай хуулийн мэдэгдэл, төлбөр хураамж, худалдан авах ажиллагааны тухай 66 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн. Дээрх мэдээллүүдийг шилэн дансны цахим сүлжээнд байршуулахаас гадна	100%

						үйлчилгээний танхимын мэдээллийн самбарт байршуулж ажилладаг.	
1.1.3 Хүн төвтэй олон нийтийн оролцоотой, иргэдэд хүрсэн төрийн үйлчилгээг хэвшүүлнэ.							
1.1.3.1	Арга хэмжээ: Дүүргийн алслагдсан хүн амд нийгмийн даатгалын үйлчилгээг “Явуулын нэг цэг”-ээр хүргэх	-	Үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	39	45	Явуулын үйлчилгээгээр Төмөр замын Агуйт зөрлөгийн 12, 14 дүгээр хэсэг, Хоолт, Хангай зөрлөг, малчин 47 өрхөд нийгмийн даатгалын ерөнхий хууль тэтгэвэр, тэтгэмжийн тухай зөвлөгөө мэдээлэл өгч 80 ширхэг гарын авлагаар хангасан. 3 иргэний тэтгэвэр тогтоолтын баримт бичгийг шалгаж, хоёр өрхөд малчны сайн дурын даатгалын талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.	100%
			Зохион байгуулсан үйлчилгээний тоо	2	1	Засаг даргын Тамгын газар болон бусад хэлтэс албадуудтай хамтран төрийн явуулын нэг цэгийн үйлчилгээг хагас, бүтэн жилийн хугацаанд хоёр удаа явж үйлчилгээ үзүүлэв.	
1.1.3.2	Арга хэмжээ: “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн 2024 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	100	100	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах 3 зорилт, 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан даргаар 2024.02.20-нд газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг 2024.06.15-нд гаргаж өгөхөөр хугацаатай байна.	100%
1.1.4 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тохижилт бүхий гудамж талбайг бий болгож, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.							
1.1.4.1	Арга хэмжээ: Байгууллага орчмын гэрэлтүүлэг, эзэмшил газарт ногоон байгууламжийг нэмэгдүүлж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд оролцож	-	Тарьсан модны тоо	2	4	Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, өрх бүр нэг мод тарих ажлын хүрээнд 260 ширхэг, “Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр албан байгууллагын гадна тайлбайд 4 төрлийн 250 ширхэг модыг хамт олны хамт тарьсан	

15

	ажилтан бүр 1 мод тарих ажлыг хэрэгжүүлэн арчлалт хамгаалалтын ажлыг сайжруулах		Ногоон байгууламж нэмэгдүүлсэн тоо	2	4	Мөн 120м2 талбайд ногоон зүлэг тарин, услах ургуулах арга хэмжээг авч ажилласан.	100%
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ							
2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:							
2.1.1 Тэтгэвэр, тэтгэмж тогтоох олгох, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах ажлыг хэрэгжүүлнэ.							
2.1.1.1	Арга хэмжээ: Иргэд, даатгуулагчдад шинээр тэтгэвэр тогтоох, олгох	-	Шинээр тэтгэвэр тогтоосон тоо	20	55	2024 онд нийт шинээр 47 тэтгэвэр тогтоосон бөгөөд Үүнээс: өндөр насны -36, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр -6, тэжээгчээ алдсаны-5 тэтгэврийг хуулийн хугацаанд тогтоосон байна. Давхардсан дүнгээр нийт 8979 тэтгэвэр авагчдад 7.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож ажилласан. Мөн тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлж ажилласан жилээ нэмэгдүүлэхээр 23 тэтгэвэр авагч хүсэлт ирүүлснээс 23 тэтгэвэр авагчийн ажилласан жилийг нэмэгдүүлэн тооцож, 612.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.	100%
			Биелэлтийн хувь	100	100	Шинээр тэтгэвэр тогтоолгохоор 47 даатгуулагч хүсэлт гаргаснаас 47 шийдвэрлэгдсэн байна.	
2.1.1.2	Арга хэмжээ: Иргэд, даатгуулагчдад тэтгэмж тогтоох, олгох	-	Шинээр тэтгэмж тогтоосон тоо	90	190	Нийгмийн даатгалын сангаас нийт 267 даатгуулагчид 4 төрлийн тэтгэмжийг олгосон байна. Үүнээс: ХЧТА-131 даатгуулагчид 22.1 сая төгрөг, ЖА-71 даатгуулагчид 240.5 сая төгрөг,	100%

						Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж-20 даатгуулагчид 40.0 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж-45 даатгуулагчид 200 сая төгрөгийг тус тус олгосон байна.	
			Биелэлтийн хувь	100	100	Нийт 267 даатгуулагч тэтгэмжийн хүсэлт ирүүлснээс 267 шийдвэрлэгдэж олгогдсон, шийдвэрлэгдээгүй тэтгэмж байхгүй.	100%
2.1.1.3	Арга хэмжээ: 6 болон 7 жилээр тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэврийг 5 жилээр өөрчлөн тогтоох	-	Хүсэлт гаргасан иргэний тоо	-	-	Тухайн жилд 6 болон 7 жилээр тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэврийг 5 жилээр өөрчлөн тогтоох хүсэлт 113 тэтгэвэр авагч ирүүлснээс 95 тэтгэвэр авагчид 8.9 сая төгрөгийн нэмэгдэл олгосон. Мөн 18 тэтгэвэр авагчийн тэтгэвэрт өөрчлөлт ороогүй.	100%
			Биелэлтийн хувь	100	100		
2.1.2 Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, зарцуулах, төвлөрүүлэх, хуваарилах ажлыг хэрэгжүүлнэ.							
2.1.2.1	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийн саналыг ахлах мэргэжилтэнд тогтоосон хугацаанд хүргэж өгөх.	-	Хэрэгжилтийн тоо	1	1	Нийгмийн даатгалын албан журмын болон сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн орлого, зарлагын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийн саналыг 2024 оны 06 сарын 24 нд боловсруулан гаргаж ахлах нягтлан бодогчид өгч нэгтгүүлэж ННДГазарт хүргүүлэв.	100%
			Хугацаа	06.30	06.30		
2.1.3 Нийгмийн даатгалын хамралт, өр авлага барагдуулах ажлыг хэрэгжүүлнэ.							
2.1.3.1	Арга хэмжээ: НДЕГ, ННДГ болон хөндлөнгийн хяналт, шалгалтын актаар тогтоогдсон зөрчил буюу	-	Актаар тогтоосон зөрчил барагдуулалтын хувь	10	20	Өмнөх оны хяналт шалгалтаар актаар тавигдсан 6.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Үүнээс жилийн эцсийн байдлаар 0,9 мянган төгрөгийг барагдуулж 5,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	

	өмнөх оны үлдэгдлийг барагдуулж ажиллах					Тайлант хугацаанд 2,4 сая төгрөг нь ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон үүнээс 2,4 сая төгрөгийг бүрэн барагдуулж, 0,08 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу 11 сарын байдлаар нийт 5,8 сая төгрөгийн авлагатай байна. Актын барагдуулалт 10,8 хувиар буурсан байна.	
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
3.1 ХУУЛЬ СУРТАЛЧЛАХ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧИРЭГДЭЛГҮЙ ШУУРХАЙ ХҮРГЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:							
3.1.1	Арга хэмжээ: Иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар үзүүлэх	-	Үйлчилгээний тоо	6	8	Нийгмийн даатгалын цахим систем буюу callpro үйлчилгээгээр 8 төрлийн үйлчилгээний тухай мэдээллийг үзүүлсэн. Бусад тэтгэвэр, 4 төрлийн тэтгэмж, сайн дурын даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, ажил олгогч өртэй эсэх лавлагаа, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа зэрэг үйлчилгээнүүдийг цахимаар үзүүлж байна.	100%
			Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	70	150	Нийгмийн даатгалын цахим систем буюу callpro үйлчилгээгээр 87 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Нийгмийн даатгалын бусад үйлчилгээг нийт 454 иргэнд үзүүлж ажилласан байна.	
3.1.2	Арга хэмжээ: Албан журмын даатгуулагчдад хууль сурталчлан таниулах, сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	-	Зохион байгуулсан сургалтын тоо	3	6	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Илч орд ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, БЗАҮАнги, Төмөр замын 12-р хэсэг, 44-р цэцэрлэг зэрэг 6 аж ахуй нэгж байгууллага 163 даатгуулагчдад нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн танилцуулга хийж, мэдээлэл хүргэн ажилласан.	100%

			Хамрагдсан хүний тоо	110	230	163 даатгуулагчдад нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн танилцуулга хийж, мэдээлэл хүргэн ажилласан.	
3.1.3	Арга хэмжээ: ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад хууль сурталчлан таниулах, сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах		Зохион байгуулсан сургалтын тоо	1	1	Эхний хагас жилд сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдан байсан байсан боловч сургуулийн амралттай давхцаж 3 дугаар улиралд хийхээр төлөвлөгдсөн.	-
			Хамрагдсан хүний тоо	25	25		
3.1.4	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахимаар олон нийтэд өргөнөөр сурталчлах, түгээх	-	Үйлчилгээний төрөл	4	8	Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалын хууль болон үйлчилгээтэй холбоотой байршуулсан 12 удаагийн видео бичлэг, шторкийг газрын "Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар" пэйж хуудсаар шейрлэж нийгмийн даатгалын хуулийг сурталчилсан. Мэдээллийг нийт 89 иргэн үзэж дагасан байна.	100%
			Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түгээсэн тоо	3	6		
3.1.5	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг иргэд, даатгуулагчдад бусад аймаг, хэлтсүүдээс цахимаар гаргаж солилцон шуурхай үйлчилгээ үзүүлэх		Гаргасан лавлагааны тоо	-	-	Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлсэн иргэдэд нийгмийн даатгалын лавлагаа цахим мэдээллийн сангаас: QR кодтой-45, батлагдсан маягтаар цаасан баримтаас гараар шивж-13, харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын хүсэлтийн дагуу:11 лавлагааг гарган өгсөн. Мөн иргэд, даатгуулагчдын хүсэлтээр тэдэнд чирэгдэлгүй шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор харьяа бусад газар луу	100%
			Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	-	-		

						хүсэлт илгээж 6 лавлагааг гаргуулан дотоод сүлжээгээр дамжуулан авч даатгуулагчдын тэтгэврийг хугацаа алдалгүй тогтоож ажилласан. Хагас жилийн хугацаанд 75 иргэнд лавлагаа мэдээлэл гаргаж өгсөн.	
ДӨРӨВ. НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ							
4.1 Хууль тогтоомж, Засгийн газар болон харъяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хангах ажлын хүрээнд:							
4.1.1	Арга хэмжээ: Зорилтот жилтэй холбогдуулан төлөвлөгөө боловсруулан шинээр ажил зохион байгуулах		Биелэлтийн хувь	100	100	Зорилтот жилийн хүрээнд 2 заалт, 8 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг хэлтсийн даргаар 2024.02.26-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу хагас жилийн биелэлтийг 2024.06.03-ны өдөр ЗДТГ-ын НХХ-т хүргүүлсэн.	-
			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	3		
4.1.2	Арга хэмжээ: Дүүргийн 35 жилийн ойн баярт зориулж шинээр 1 ажил зохион байгуулах	-	Биелэлтийн хувь	100	100	Засаг даргын дэргэдэх 7 хэлтэс, албадтай хамтран Дүүргийн 35 жилийн ойг угтсан урлагийн арга хэмжээнд амжилттай оролцсон.	100%
			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1		
4.1.3	Арга хэмжээ: Төрийн бус болон олон улсын байгууллагатай хамтран төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх	2000.0	Биелэлтийн хувь	100	100	Өсвөрийн дуудлага төрийн бус байгууллагатай хамтран Хамтын хөгжил төсөл (сургалт)-г 2024 оны 06 дугаар сарын 20-с 21-ны өдөр зохион байгуулахаар болсон. Хамтран ажиллах ТББ-ын сургалтын дарааллаар тус арга хэмжээ 6 дугаар сард зохион байгуулагдахаар байна.	-
			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	1		
4.1.4	Арга хэмжээ: Байгууллагын болон албан хаагчдын аюулгүй байдлыг хангахад камержуулах ажлыг хэрэгжүүлэн ажиллах	-	Биелэлтийн хувь	100	100	Байгууллагын гадна, дотоод орчин, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс дотор камер 1 ширхэг, гадна 3 ширхэг камер байршуулсан, хэвийн ажиллаж байна.	100%
			Байршуулсан камерын тоо	3	3		

4.2 Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж сайжруулна							
4.2.1	Арга хэмжээ: Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг мөрдөж, ирсэн явсан бичгийн бүртгэл, шийдвэрлэлтэд хяналт тавих	-	Шийдвэрлэлтийн хувь	100	100	Нийт албан хэрэг хөтлөлтийн ер цахим системээр 123, able програмаар 113 албан бичиг ирснийг хүлээн авч бүртгэл хөтлөн газрын даргад танилцуулан хариутай 79 албан бичгийг холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь шийдвэрлүүлсэн ба бусад байгууллагуудад 40 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан явуулж ажилласан.	100%
4.2.2	Арга хэмжээ: Иргэдээс ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариу өгөх	-	Ирсэн өргөдлийн тоо	5	10	Газрын хэмжээнд тайлант хугацаанд байгууллага, иргэнээс 18 хүсэлтийг хүлээн авч холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь хуулийн хүрээнд шийдвэрлэж хариуг шуудангаар, утсаар хүргүүлсэн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног байна.	100%
			Шийдвэрлэсэн хувь	100	100		
4.2.3	Арга хэмжээ: Байгууллагын архивын баримтыг холбогдох хуулийн дагуу хүлээн авах, хадгалах, ашиглуулах, хамгаалах ажлыг зохион байгуулах.	-	Хүлээн авсан баримтын тоо	116	0	Эхний хагас жилд 3 албан хаагчаас 80 боть архивын баримт, зогсоогдсон 30 хувийн хэрэг хүлээн авч стандартын дагуу бүртгэж архивласан. Мөн байгууллагын Баримт нягтлан шалгах комисс хуралдаж, хөтлөх нэрийн үлгэрчилсэн 89 төрлийн салбарын 23 жагсаалтыг боловсруулан батлуулсан.	100%
			Ашиглуулсан баримтын тоо	-	-		
4.2.4	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын сан, санхүүгийн анхан шатны бүртгэл хөтлөх, тайлан, мэдээ гаргах ажлыг хэрэгжүүлэх.	-	Тайлан мэдээний тоо	2	2	Тайлангуудыг хуулийн хугацаанд дээд шатны, болон бусад холбогдох шатны байгууллагад тайлагнаж, ил тод байдлыг ханган, цахим систем, мэдээллийн самбарт мэдээллэж ажилласан.	100%

4.2.5	Арга хэмжээ: Байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан маягтын дагуу боловсруулан баталгаажуулах, үр дүнг тооцуулах.	-	Хэрэгжилтийн хувь	100	100	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаарын тушаалын хавсралт маягтаар чиг үүргийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 албан хаагч боловсруулан, газрын даргаар батлуулж, биелэлтийг бүтэн жилийн байдлаар тайлагнан дүгнүүлж байна.	100%
4.2.6	Арга хэмжээ: Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг тооцож, хэрэгжилтийг хангах		Хэрэгжилтийн хувь	100	100	Тухайн жилийн байдлаар: - Засгийн газрын тогтоол 3 -Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол- 1 Монгол Улсын сангийн сайдын тушаал 1 Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал 9 Улсын ерөнхий прокурор, Хууль зүйн дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал 1 МУ-н Соёл, спорт аялал жуулчлал залуучуудын яамны төрийн нарийн бичгийн даргын тушаал 1 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаал 1 - НДЕГ-ын даргын тушаал-36 - Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал-1 НЗД-ын захирамж-4 БХД Засаг даргын захирамж-19 - Багахангай дүүргийн онцгой комиссын даргын тушаал-1 зэрэг 77 тогтоол шийдвэр ирсэн бөгөөд 49 тогтоол шийдвэрийн гүйцэтгэлийг ханган, бусад шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	100%

4.2.7	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах		Зохион байгуулсан сургалтын тоо	6	12	2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн үе шатлалтай явагдсан цахим сургалтуудад, албан хаагчид бүгд идэвхтэй хамрагдсан. 2024.04.02-ны өдрийн УИХ-ын ХЗБХ-ны 5 тогтоолоор мэдүүлэг гаргах албан тушаалтаны жагсаалт, мэдүүлэгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтаны баталгааны маягт шинэчлэгдсэнтэйгээр зохион байгуулагдсан УБАТ-уудын цахим сургалтанд хамрагдсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх” сэдвээр малчин даатгуулагчдыг сайн дурын даатгалд хамруулах, гадаадын орнуудын туршлагаас сонсож, хуулийн өөрчлөлтийн талаар болон гадаадын орнуудад хэрэгжиж байгаа талаарх сургалт, хэлэлцүүлэгт орлого шимтгэлийн байцаагч хамрагдсан.	100%
			Хамрагдсан хүний тоо	6	6		
4.2.8	Арга хэмжээ: Төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцаатай болон бусад захирамжлалын баримт бичгийг хууль зүйн үндэслэлтэй боловсруулах	-	Боловсруулсан захирамжлалын баримт бичгийн тоо	45	-	Тухайн жилд боловсон хүчний буюу хөдөлмөрийн харилцаатай холбоотой Б тушаал 30, үндсэн үйл ажиллагааны тухай А тушаал 19-г хууль зүйн үндэслэлтэй боловсруулан гаргасан.	100%
4.2.9	Арга хэмжээ: Төрийн албан хаагчдыг шударга, нээлттэй зарчмаар сонгон	-	Сул орон тоо гарсан тоогоор	2	2	Газар нь 6 хүний бүтэц орон тоотой бөгөөд одоогоор бүтэц орон тооны дутагдалгүй ажиллаж байна.	

43

	шалгаруулж төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэх						100%
4.2.10	Арга хэмжээ: НДЕГ-аас баталсан бүтэц, орон тоонд багтаан ажиллаж, хүний нөөцийн өөрчлөлт, хөдөлгөөний тайлан гаргах, цахим системд бүртгэх	-	Батлагдсан бүтцийн тоо	6	-	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/52 дугаар тушаалаар 6 орон тоотой батлагдсан бөгөөд орон тооны хэтрэлгүй 1 албан хаагч албан тушаал хавсран гүйцэтгэж 6 хүний бүтцээр ажиллаж байна. Хүний нөөцийн тоог грийн цахим системээс хөрвүүлэн, цалингийн хүснэгтийн хамт баталгаажуулан сар бүр дотоод сүлжээгээр, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг улирал бүр хэвлэмэлээр ННДГ-ын Хүний нөөцийн мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан.	100%
			Тайлан мэдээний тоо	4	2		
4.2.11	Арга хэмжээ: Албан хаагчидтай холбоотой ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сайжруулах, сургалт зохион байгуулах, сургалтанд хамрагдах	-	Зөрчил шийдвэрлэлтийн тоо	-	-	Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага, ур чадварыг дээшлүүлэх Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулж буй цахим сургалтуудад албан хаагч нар идэвхтэй хамрагдаж байгаа бөгөөд албан хаагчидтай холбоотой ёс зүйн асуудал гараагүй байна.	100%
			Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	-	1		
4.2.12	Арга хэмжээ: Албан хаагчдыг албан хэрэг хөтлөлт, боловсруулалтын чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамруулж, мэдлэг, ур чадварыг сайжруулах	-	Хамрагдсан хүний тоо	4	4	Багахангай дүүргийн архивын газраас зохион байгуулсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-н талаар сургалтад байгууллагын Бичиг хэргийн ажилтан 2024.03.26-ны өдөр, бусад албан хаагчид цахимаар хамрагдсан.	100%
			Сургалтын тоо	1	1		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.	Арга хэмжээ: Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ судлах	-	-	-	-	Хуулийг уншиж судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
2.	Арга хэмжээ: Монгол хэлний тухай хууль, Засгийн газраас 2020 онд баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-(2020-2024)-"ийн хэрэгжилтийг ханган суралцах.	-	-	-	-	Монгол бичгийн чадварыг дээшлүүлэх сургалтанд хамрагдахаар бүртгүүлсэн.	-

БИЕЭЛЭЛТ ГАРГАСАН:

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН БАЙЦААГЧ,
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

..... / А.Мөнхцэцэг/
(Нэр, гарын үсэг)

2024.12.02
(Огноо)

90